"Монста Аудит"
Нягтлан бодох бүртгэл, хяналтын хараат бус
хөндлөнгийн итгэмжлэгдсэн байгууллага

АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

"ХАН АЛТАЙН НУРУУ ББСБ" ХХК

2020 оны 12-р сарын 31

Монгол улс, Улаанбаатар хот, ЧДүүрэг, 6-р хороо,
Вертикаль ХХК –ийн байр 26-1 тоот
Харилцах утас: 99082367, 99015686
И-мэйл хаяг: y_erdenechimeg@yahoo.com

ХАРААТ БУС АУДИТЫН ТАЙЛАН

"ХАН АЛТАЙН НУРУУ ББСБ" ХХК -ын захирал Х.Хандсүрэн танаа

ДҮГНЭЛТ

Бидний дүгнэлтээр **"ХАН АЛТАЙН НУРУУ ББСБ" ХХК** -ын 2020 оны 12 - р сарын 31 - ний өдрөөр тасалбар болсон санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүн болон мөнгөн гүйлгээ нь санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн байна.

Аудитын дүгнэлтийн үндэслэл

Бид **"ХАН АЛТАЙН НУРУУ ББСБ" ХХК** -ын 2020 оны 12 - р сарын 31 - ний өдрийн байдлаарх санхүүгийн байдлын тайлан, орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд ба бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайланд "Аудитын Олон Улсын Стандарт" - ын дагуу аудит хийж гүйцэтгэлээ. Бидний гүйцэтгэсэн аудит нь бидний гаргасан дүгнэлтэнд хангалттай, зохистой үндэслэл болж чадна гэдэгт бид итгэлтэй байна.

Тасралтгүй үйл ажиллагааны зарчимтай холбоотой асуудлууд

Тасралтгүй үйл ажиллагаатай холбоотой материаллаг тодорхой бус байдал үүсссэн тохиолдол бидэнд ажиглагдаагүй болно. Тус байгууллага нь үйл ажиллагаагаа цаашид хэвийн бөгөөд тасралтгүй явуулна гэсэн төсөөллөөр санхүүгийн тайлангаа бэлтгэсэн байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн үнэлэмж шийдлээр тайлант үеийн санхүүгийн тайланд хамгийн их нөлөөлөл үзүүлэх зүйлсийг аудитын гол асуудлууд гэж үзнэ. Санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд эдгээрийг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба тусад нь дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд удирдлага болон засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн хүлээх хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг "Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт" болон "Нягтлан Бодох Бүртгэлийн Тухай Хууль"-ийн дагуу бэлтгэж, үнэн зөв танилцуулах нь удирдлагын үүрэг хариуцлага юм.

Энэхүү үүрэг хариуцлагад нягтлан бодох бүртгэлийн зохистой бодлогуудыг сонгон авч хэрэглэх, байгууллагынхаа үйл ажиллагаанд тохирсон нягтлан бодох бүртгэлийн тооцооллуудыг хийх, санхүүгийн тайлангуудыг аливаа заль мэх эсвэл алдаанаас шалтгаалсан материаллаг буруу илэрхийлэлгүйгээр, үнэн зөвөөр толилуулахтай холбоотой дотоод хяналтыг бий болгох, хэрэгжүүлэх зэрэг багтана.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь байгууллагын санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүргийг хүлээнэ.

Аудитын хүлээх хариуцлага

Хийж гүйцэтгэсэн аудитдаа үндэслэн эдгээр санхүүгийн тайлангуудад хараат бус дүгнэлт өгөх нь бидний үүрэг юм. Бид аудитаа "Аудитын Олон Улсын Стандарт" - ын дагуу хийж гүйцэтгэсэн. Эдгээр стандартууд нь санхүүгийн тайлангууд нь материаллаг алдаагүй эсэх талаар зохистой нотолгоо олж авахын тулд аудитаа төлөвлөж гүйцэтгэх, шаардлагуудыг мөрдөж ажиллахыг шаарддаг.

Аудитын ажилд санхүүгийн тайлангийн дүн болон тодруулгуудын талаар аудитын нотолгоо олж авах горимуудыг гүйцэтгэх ажил багтана. Аудитын горимуудын сонголт нь санхүүгийн тайлангууд нь аливаа заль мэх, алдаанаас шалтгаалан материаллагаар буруу илэрхийлэгдэх эрсдлүүдийн үнэлгээг багтаан аудиторын шийдлээс хамаарна.

Тэдгээр эрсдлүүдийн үнэлгээг хийхдээ аудитор санхүүгийн тайлангуудыг үнэн зөв бэлтгэн толилуулахтай холбоотой байгууллагын дотоод хяналтын системийг харгалзан үзэх бөгөөд энэ нь байгууллагын дотоод хяналтын үр дүнтэй байгаа эсэх талаар дүгнэлт өгөх зорилгоор биш, харин нөхцөл байдалдаа тохирсон аудитын горимуудыг тодорхойлоход чиглэнэ. Аудитад мөн байгууллагын удирдлагын сонгон хэрэглэж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын зохистой эсэх, нягтлан бодох бүртгэлийн тооцооллуудын бодитой эсэхийг үнэлэх ажлууд багтана.

Санхүүгийн тайлангийн хураангуй үзүүлэлтүүдийг хавсаргав.

ПАРТНЕР **В.ЭРДЭНЭЧИМЭГ**

Огноо: 2021 - 03 - 15

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
6-р хороо,Вертикаль ХХК-ний байр, 209 тоот
Харилцах утас: 99082367
И-мэйл хаяг: v_erdenechimeg@yahoo.com

Хавсралт-3

"ХАН АЛТАЙН НУРУУ ББСБ" ХХК-ын 2020 оны 12 сарын 31-ний өдрөөрх өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлтүүд	Хувьцаат капитал	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	НИЙТ ДҮН
2019 оны 12-р сарын 31-рх үлдэгдэл	2,500,000.0						319,651.3	**2,819,651.3**
НББ-н өөрчлөлтийн нөлөө, залруулга								
Залруулсан үлдэгдэл								
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт								
Хуваарилсан ногдол ашиг							-319,651.3	**-319,651.3**
Хувьцаат капиталын өсөлт								
Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал							384,655.9	**384,655.9**
2020 оны 12-р сарын 31-рх үлдэгдэл	**2,500,000.0**						**384,655.9**	**2,884,655.9**

"ХАН АЛТАЙН НУРУУ ББСБ" ХХК-ын 2020 оны 12 сарын 31-ний өдрөөрх мөнгөн гүйлгээний тайлан

/ мян.төг /

Үзүүлэлтүүд	2020 он	Аудитлагдсан
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(73,481.80)	(73,481.80)
Үндсэн бус үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(7,220.70)	(7,220.70)
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	***(80,702.50)***	***(80,702.50)***
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	***599,473.0***	***599,473.0***
Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	***518,770.5***	***518,770.5***

МОНСТА АУДИТ ХХК БАТАЛГААЖУУЛАВ ХНТ0752

"ХАН АЛТАЙН НУРУУ ББСБ" ХХК-ын 2020 оны 12 сарын 31-ний өдрөөрх орлогын дэлгэрэнгүй тайлан

/ мян.төг /

Үзүүлэлт	Аудитлагдсан
Хүүгийн орлого	624,537.20
Хүүгийн зардал	-
Нийт ашиг/алдагдал/	**624,537.20**
Хүүгийн бус орлого	55,476.30
Хүүгийн бус зардал	228,315.20
Цэвэр хүүгийн бус орлого зардал	**(172,838.90)**
Болзошгүй эрсдлийн сан байгуулахаас өмнөх үйл ажиллагааны ашиг /алдагдал/	**451,698.30**
Болзошгүй эрсдлийн сан	
Үндсэн бус үйл ажиллагааны ашиг /алдагдал/	**451,698.30**
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	
Үндсэн бус үйл ажиллагааны зардал	21,140.80
Ердийн үйл ажиллагааны ашиг /алдагдал/	**430,557.50**
Ердийн бус орлого	
Ердийн бус зардал	
Татварын төлөхийн өмнөх ашиг /алдагдал/	**430,557.50**
Орлогын татварын зардал	45,901.60
Татварын дараах цэвэр ашиг /алдагдал/	**384,655.90**

МОНСТА АУДИТ ХХК
БАТАЛГААЖУУЛАВ
ХН10752 Д. 5200896

Хавсралт-1

"ХАН АЛТАЙН НУРУУ ББСБ" ХХК-ын 2020 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн байдлын тайлангийн хураангуй үзүүлэлт

/ мян.төг /

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	599,473.0	518,770.5
Богино хугацаат хөрөнгө оруулалт		
Зээл /цэвэр/	1,898,926.4	2,307,866.7
Санхүүгийн түрээсийн тооцооны авлага		
Факторингийн тооцооны авлага		
Санхүүгийн деривативын авлага		
Бусад авлага	283,224.7	223,180.9
Бусад хөрөнгө	5,304.3	4,188.5
Эргэлтийн хөрөнгийн дүн	**2,786,928.4**	**3,054,006.6**
Үндсэн хөрөнгө	38,796.3	45,144.4
Биет бус хөрөнгө	7,667.0	7,554.5
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	**46,463.3**	**52,698.9**
Нийт хөрөнгийн дүн	**2,833,391.7**	**3,106,705.5**
Богино хугацаат өр	13,740.4	222,049.6
Урт хугацаат өр		
Өр төлбөрийн нийт дүн	**13,740.4**	**222,049.6**
Энгийн хувьцаа	2,500,000.0	2,500,000.0
Халаасны хувьцаа		
Нэмж төлөгдсөн капитал		
Хандивын капитал		
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		
Хоёрдогч өглөг		
Хуримтлагдсан ашиг/алдагдал/	319,651.3	384,655.9
Нөөцийн сан		
Нийгмийн хөгжлийн сан		
Эздийн өмчийн дүн	**2,819,651.3**	**2,884,655.9**
Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	**2,833,391.7**	**3,106,705.5**

МОНСТА АУДИТ ХХК
БАТАЛГААЖУУЛАВ
ХНТ0752 Д. Бадрах